



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 06.

Улаанбаатар хот

Ёс зүйн хороо байгуулах тухай

МУ-ын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрэм, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай албан хаагчийн гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий Ёс зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Ёс зүйн хорооны
дарга:

Д.Жаргалсайхан /Атракци хариуцсан мэргэжилтэн/

Гишүүд:

Г.Гансүвд /Гадаад харилцаа хамтын ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн/

Нарийн бичиг:

Э.Мөнхзүл /Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн/

Хоёр. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай албан хаагчийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхдээ Иргэдээс албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, тус газрын Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан ёс зүйн хэм хэмжээг зохицуулсан холбогдох заалтуудыг баримтлан, шалгасан дүнг хуралдаанаараа хэлэлцэж, тайлан, мэдээг улирал тутам гарган, мэдээлж ажиллахыг Ёс зүйн хороо /Д.Жаргалсайхан/-нд даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР